

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29-ны өдөр

№ 01/2023

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.9, 8.14, болон тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/2023 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР



“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Түмэн шувуут” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2022 оны зорилтуудын гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, “Түмэн шувуут” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигч нарт танилцуулж байна.

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг удирдах үйл ажиллагаандаа засаглалыг сайжруулах арга чиглэл, зарчмуудыг баримталж, компанийн тухай хууль, бусад дүрэм, журмыг мөрдлөг болгон тус компанийн 2022 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтыг хэлэлцэн баталж, Гүйцэтгэх удирдлагын багийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, зөвлөмжөөр хангаж амжилттай ажиллалаа.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос өгсөн чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх удирдлагын баг нь Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах, компанийн дотоод хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох зорилгоор дотоод хяналтын багийг томилон ажиллаж байна.

Мөн компанийн дүрмийн 21.1 дүгээр заалтын дагуу "Эрх бүхий албан тушаалтнууд болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан үүнд хамаарна" гэх заалтад хамаарах эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтыг шинэчлэн гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлаж ажилласан. Цаашлаад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д заасны дагуу компанийн дотоод мэдээлэл эзэмшигчдийн жагсаалтыг гаргаж, ТУЗ-өөр батлуулахад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

2022 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулахын тулд улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж, үйл ажиллагаанд хяналт тавихаар зорьсон бөгөөд үүний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ нь 2022 онд хуралдах хурлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалт, гарфикийг гаргаж баталсан нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулалтын хувьд цэгцтэй, дэс дараатайгаар явуулахад чухал ач холбогдолтой ажил болсон гэж үзэж байна. Цаашид уг ажлыг хэвшүүлэн тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай юм.

- 2022 онд Компанийн засаглалын кодексын өөрийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд авбал зохих 72 онооноос 60 оноо авч 83.3%-ийн үнэлгээ авсан нь компани цаашид засаглалын хувьд эрсдэл үүсч болзошгүй асуудлууддаа холбогдох дүрэм, журмын хүрээнд сайжруулалт хийж ажиллах шаардлагатай гэж үзсэн. Уг шаардлага нөхцлийн хүрээнд өнгөрсөн онд ТУЗ нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. ТУЗ-ийн дэргэдэх Ёс зүйн хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллав.
2. Компанийн Ёс зүйн дүрэм батлуулж, уг дүрмийг бүх удирдлагууд, үйлдвэрийн ажилтнуудад танилцуулах ажлыг зохион байгуулав.
3. Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулав.
4. Цалин урамшууллын бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн хурлаар батлав.
5. Мэдээллийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн ТУЗ-ийн хурлаар батлав.
6. Дотоод хяналтын ажилтан болон дотоод хяналт хийх багийг томиллов.
7. Комплайнсын ажилтан томилж, хяналтын зааврыг батлав.

Дээрх хийж гүйцэтгэсэн ажлууд нь компанийн засаглалыг сайжруулахад тодорхой нөлөө үзүүлэхүйц ажил болж чадсан гэж дүгнэж байна.

Иймд “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-өөс тус хувьцаат компанийн 2022 оны санхүүгийн тайланд дараах дүгнэлтийг өгч байна.

“Түмэн шувуут” хувьцаат компани 2022 онд 97.7 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос **22%-иар** (өмнөх онд 80.0 сая ширхэг өндөг) өссөн бол малын тэжээлийн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад **18%-иар** нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн 2022 онд нийт 854.0 тн органик бордоо, 222.0 тн шингэн өндөг үйлдвэрлэсэн байна.

“Түмэн шувуут” ХКомпани нь 2021 онд 36.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан бол 2022 онд 46.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого хийж, өмнөх оноос **28%-иар** өссөн үзүүлэлттэй ажилласан байна.

2022 оны нийт зардал 37%-иар өссөнд зах зээл дээрх валютын ханшийн өөрчлөлт, түүхий эдийн үнийн өсөлт, инфляцийн өсөлт нөлөөлсөн.

2021 онд 6.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бол 2022 онд 7.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өмнөх оноос **4%-иар** өссөн үзүүлэлттэй гарсан байна.

2022 онд өндөглөгч тахианы нэг байр өсвөр шувуу бойжуулах нэг байр тэжээлийн түүхий эд хадгалах 1000 тн-ын 3 нөөцийн сав барьж байгуулах ажлыг төлөвлөсөн бөгөөд энэ ажилд 5,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, бид үйл ажиллагаагаа амжилттай тэлж ажилласаар байна.

Бүтээн байгуулалтын тухайд СХД-ийн 21 дүгээр хороо, Их булагт байрлалтай шинэ шувууны аж ахуйд нэмж 2 байрыг ашиглалтад оруулж, 10 ажилтан нэмж авсан нь 2022 оны үйлдвэрлэлийн тоог өсгөхөд тодорхой хувь нэмрээ оруулсан гэж дүгнэж байна. 2023 онд дэгдээхэйн болон өндөглөгчийн 2 байрыг шинээр барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа нь хэрэглэгчдийн хүлээлтэд нийцсэн ажил болж байна гэж үзэж байна.

Цаашид органик бордооны үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, төрийн худалдан авалтын шалгаруулалтад оролцох, уул уурхайн нөхөн сэргээлт, тариаланчид болон хүлэмжийн аж ахуй эрхлэгчид зэрэг холбогдох салбарын түншүүдэд бүтээгдэхүүнээ сурталчилан таниулах, хамтран ажиллах замаар бордооны борлуулалтыг нэмэгдүүлэхэд зорьж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Дүгнэлт

- Тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн нь компанийн цэвэр ашиг өсөхөд нөлөөлжээ. Импортын барааны хилийн хориг зэрэг хүндрэлтэй нөхцөл байдалд авч хэрэгжүүлсэн менежментийн бодлого, арга хэмжээний үр дүнд нь компанийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөж, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлж чадсан байна.
- “Түмэн шувуут” ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн баталсан заавар, журам, аргачлал, стандартын дагуу үнэн зөв тайлагнаж ажиллажээ.
- Иймд Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Түмэн шувуут” Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагын багийг 2022 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж дүгнэж байна.

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29-ны өдөр

№ 02/2023

Улаанбаатар хот

Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах, компаний дүрмийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8 дахь заалтууд, 12 дугаар зүйлийн 12.1, 12.6, 12.7 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалт болон тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03/2023 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” Хувьцаат компанийг “Агро фийд бордоо” гэсэн оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ үүсгэн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Агро фийд бордоо” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн оршин байх газар буюу хууль ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 27-р хороо, 21-р хороолол, 21-р гудамж, 59 тоотод байхаар тогтоосугай.
3. Компанийг үүсгэн байгуулахад оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1.000.000 /нэг сая/ төгрөг бөгөөд нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10.000 /арван мянга/ ширхэг энгийн хувьцааг гаргахаар тогтоосугай.
4. Компани нь хугацаагүйгээр дараах үйл ажиллагаа явуулсугай. Үүнд:
 - 4.1 *Малын тэжээлийн үйлдвэрлэл*
 - 4.2 *Бордооны үйлдвэрлэл*
 - 4.3 *Гадаад дотоод худалдаа*
5. “Компанийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
6. Компанийн үүсгэн байгуулах болон гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
7. Компани үүсгэн байгуулахтай холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах хороонд мэдэгдэх, Улсын бүртгэлийн газарт хандаж бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

“Түмэн шувуут” ХК-ийн ХЭЭХурлын
2023 оны 04 дүгээр сарын 28-ний
өдрийн 02/тоот тоотлолын хавсралт



**“ АГРО ФИЙД БОРДОО”
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Компанийн оноосон нэр:

а) Монголоор: “Агро фийд бордоо” ХХК /цаашид энэхүү дүрэмд “Компани” гэх/

б) Англиар: “Agro feed bordoo” Co,Ltd

1.2.Компанийн оршин байгаа газар:

- Улсын нэр: Монгол Улс
- Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот
- Сум, дүүргийн нэр: Сонгино Хайрхан дүүрэг
- Баг, хороо, хорооллын нэр: 27-р хороо, 21 хороолол
- Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: 21-р гудамж
- Хашаа, байшин, хаалганы дугаар: 59 тоот
- Харилцах утасны дугаар: 976-11-70005225
- Факсын дугаар: 976-11-70005225
- И-мэйл хаяг: info@tumenshuvuut.mn

1.3.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл.

1.3.1.Хуулийн этгээдийн тухайд:

- Хуулийн этгээдийн нэр, хэлбэр: “Түмэн шувуут” ХК
- Улсын бүртгэлийн дугаар: 000188646
- Регистрийн дугаар: 2844753

1.4.Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.

1.5.Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

1.5.1. Малын тэжээлийн үйлдвэрлэл

1.5.2. Бордооны үйлдвэрлэл

1.5.3 Гадаад дотоод худалдаа

1.6. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.7. Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: **Хугацаагүй**

1.8. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.9.Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Хоёр. Компанийн эрх

- 2.1. Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.
- 2.2. Компани нь өөрийн бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
- 2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
- 2.4. Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 2.5. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

Гурав. Компанийн үүрэг

- 3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.
- 3.2. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
- 3.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
- 3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
- 3.6. Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу үйлдвэрийн удирдлагыг мөн компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 3.7. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

Дөрөв. Компанийн хариуцлага

- 4.1. Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.
- 4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- 4.3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.
- 4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 4.5. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.
- 5.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1.000.000 /нэг сая/ төгрөг ба нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10.000 /арван мянга/ ширхэг энгийн хувьцаа байна.

5.3 Компани нь 1 /нэг/ хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 хувь эзэмшинэ.”

Хувьцаа эзэмшигчийн нэр, регистр	Хаяг	Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо	Нэгж үнэ	Эзэмшиж буй хувьцааны үнэ	Эзэмшлийн хувь хэмжээ
“Түмэн шувуут” ХК Рег № 2844753		Энгийн хувьцаа ширхэг	төгрөг	төгрөг	хувь
		ХУД 13-р хороо, Туул тосгон	10.000	100	1.000.000

5.4 Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.

5.5 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

5.6 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтлана.

5.7 Компанийн хувьцаа, компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.

Зургаа. Компанийн удирдлага

6.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ.

6.2. Компанийн гүйцэтгэх захирлыг хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр сонгож, өөрчилнө. Гүйцэтгэх захиралтай хувьцаа эзэмшигч гэрээ байгуулна.

6.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь компаниа өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдлэнэ.

Долоо. Гүйцэтгэх удирдлага

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

7.2. Компанийн гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

7.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх захирал байж болно. Энэ тохиолдолд үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчийн шийдвэрт тусгах бөгөөд гэрээ байгуулахгүй.

7.4. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

Найм. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

8.1. Компанийн хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэгт зааснаар гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.

8.2. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

8.3. Компанийн жилийн санхүүгийн тайлан баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.

8.4. Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч хариуцан төлнө.

8.5. Компани нь санхүүгийн тайлангаа эрх бүхий этгээдэд танилцуулна

- 8.6.Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.
- 8.7.Компани нь компанийн санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.
- 8.8.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

Ес. Компанийг өөрчлөн байгуулах

- 9.1.Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Арав. Компанийг татан буулгах

- 10.1.Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.
- 10.2.Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.
- 10.3.Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.
- 10.4.Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 10.5.Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад ирүүлнэ.

Арван нэг. Бусад зүйл

- 11.1.Энэхүү дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж, нэг хувийг бүртгэх байгууллагад, хоёр хувийг компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх эрх бүхий этгээдэд өгнө.
- 11.2.Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.

-----oOo-----